



МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН  
ҮНДЭСНИЙ ПАРКЫН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2021 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 1A-05

Улаанбаатар хот

Г 1

Инкубаторын дараах үйлчилгээний журам  
батлах тухай

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.11 дэх заалтууд, Монгол улсын Засгийн газрын 194-р тогтоол, Мэдээллийн технологийн үндэсний паркын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.6.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Мэдээлэл, технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-н Инкубаторын дараах үйлчилгээний журмыг хавсралтаар баталсугай.
2. Инкубаторын дараах үйлчилгээний журмыг батласантай холбогдуулан 2021 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
3. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төслийн удирдлага, сургалт, маркетингийн хэлтсийн дарга /П.Наранцэцэг/-д үүрэг болгосугай.



Э.ЦОГТГЭРЭЛ



## ИНКУБАТОРЫН ДАРААХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Мэдээлэл, технологийн “инкубаторын дараах үйлчилгээ” (цаашид хүсэлт гаргагч гэх) мэдээлэл, технологийн инкубаторт /инкубаторын дараах үйлчилгээ/ (цаашид инкубатор гэх) элсүүлэх, дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад энэхүү журмыг баримтална.
- 1.2. **Инкубаторын дараах үйлчилгээний зорилго нь** бизнес инкубаторын хөтөлбөрийг амжилттай төгсөгч компанийг гадаад, дотоодын зах зээлээс хөрөнгө оруулалт татах, эхэлсэн төслийг дуусгах, МТҮП-тэй хамтран ажиллах, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, ажлын байрыг хөнгөлөлттэй үнээр ашиглуулж, оюуны өмч, хууль эрх зүйн чадамжтай компани болоход нь дэмжлэг үзүүлэхэд оршино.
- 1.3 Энэхүү үйлчилгээнд хамрагдах хүсэлт гаргасан компани нь 2.1 дэх заалтын шаардлагуудыг хангасан байна
- 1.4. Компанид дэмжлэг үзүүлэх хугацаа 5 хүртэлх жил байх бөгөөд хугацааг тодорхойлохдоо энэхүү журмын 1.3-г үндэслэл болгоно.
- 1.5. Хүсэлт гаргасан компанийг энэхүү үйлчилгээнд хамрагдах эсэхийг тодорхойлохдоо ажлын хэсгийн төгсөлтийн үнэлгээ, явцын үнэлгээний дүн зэргийг харгалзан үзнэ
- 1.6. 1.4 дэх заалтын хангасан хүсэлт гаргагчийг Парк нь ажлын байрны боломж, хүрэлцээг харгалзан үзэж инкубаторын дараах үйлчилгээнд хамрагдах эсэхийг шийдвэрлэнэ.
- 1.7. Энэхүү журам нь паркын холбогдох дүрэм журам, гэрээний салшгүй гэсэн байна.

### Хоёр. Инкубаторын дараах үйлчилгээнд хамрагдахад тавигдах шаардлага, нөхцөл

- 2.1 Хүсэлт гаргагч компани нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - 2.1.1 Мэдээлэл, технологийн үндэсний паркын инкубаторын төгсөлтийн үнэлгээний дүн нь 80-100% байх;
  - 2.1.2 Инкубатор төгсөгч компани нь үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ төгсөлтийн үнэлгээнд орохоос 15 хоногийн өмнө албан бичгээр өгсөн байх; (Төгсөөд ирж байгаа компани нь 30 хоногийн өмнө хүсэлтээ албан бичгээр өгсөн байх)
  - 2.1.3 Энэхүү журмын 1,2-р заалтын шаардлага хангасан байх

2.2 Хүсэлт гаргагч компани нь дараах болзол, нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрсөн байна. Үүнд:

- 2.2.1. Паркын инкубаторт байрлаж байгаа гарааны компанийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хамтын ажиллагаа өрнүүлэх; (1 буюу түүнээс дээш)
- 2.2.2. Хөрөнгийн барьцаа байршуулах;
- 2.2.3. МТҮП-ын дотоод журам, инкубаторын үйл ажиллагааны журам болон бусад холбогдох дүрэм журмыг даган мөрдөж ажиллах;

### **Гурав. Үйлчилгээ**

3.1. ААН-д дараах үйлчилгээг үзүүлнэ.

Үүнд:

- 3.1.1. Ажлын байрны түрээсийн төлбөрийг 20 хүртэлх хувийн хөнгөлөлттэй байршуулах;
- 3.1.2. Хөрөнгө оруулалт олоход гарааны компаниудад дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах;
- 3.1.3. Нийгмийн хариуцлагын хүрээнд зохион байгуулж буй арга хэмжээнүүдэд холбогдох журмын дагуу өрөө танхимыг хямдралтай үнээр ашиглуулж болно;

### **Дөрөв. Хамтын ажиллагаа**

- 4.1. Инкубаторыг төгсөгч компани нь шинээр элссэн компаниудад зөвлөгөө, сургалт, хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, зуучлах;
- 4.2. Гадаад болон дотоодын төсөл хөтөлбөр, тендерүүдэд хамтарч ажиллах,
- 4.3. Мэдээлэл, технологийн үндэсний паркаас зохион байгуулж буй арга хэмжээнүүдэд хамтарч ажиллах;
- 4.4. Инкубаторын үйлчилгээнд хамрагдсан компаниуд нь бүтээгдэхүүн үйлчилгээгээ паркад хөнгөлттэй нөхцөлөөр ашиглуулах;

### **Тав. Инкубаторын дараах үйлчилгээг дуусгавар болгох**

5.1. Дараахт шалтгаануудын аль нэгийг үндэслэл болгон МТҮП-ын захирлын шийдвэрээр компанийг инкубаторын үйлчилгээг зогсоно. Үүнд:

- 5.1.1. Хамтын ажиллагааны гэрээнд заагдсан үүргээ биелүүлээгүй;
- 5.1.2. Хамтын ажиллагааны гэрээ байгуулснаас хойш ажлын 10 хоногийн дотор инкубаторт байрлаагүй бол;
- 5.1.3. Инкубаторын үйл ажиллагааны журам, хамтын ажиллагааны гэрээг ноцтойгоор зөрчсөн бол;
- 5.1.4. МТҮП-ын дотоод журмын холбогдох заалтуудыг зөрчсөн бол;
- 5.1.5. Энэхүү журмын 5.1.3 дахь заалтыг хангаж ажиллаагүй бол компанийн үйлчилгээг зогсоож, компанийн хөрөнгийн болон үүрэг хариуцлагын баталгаа болох барьцааг төлбөрийг буцаан олгохгүй;

### **Зургаа. Бусад**

6.1. Үйлчилгээнд хамрагдаж буй компаниуд хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллана.

6.2. Инкубаторыг төгсөн гарсаны дараа буюу 0-3 хүртэлх сарын дотор үргэлжүүлэн орох хүсэлт гаргавал үйлчилгээнд хамрагдах боломжтой.